



19th Story

Загалмайд цовдлогдон нас барсан нь

Crucifixion

Загалмайд цовдлогдон нас барсан нь!

– 19th Story –



Өгүүлэгч

Есүс Ромын цэргүүдэд зодуулан доромжлуулсан. Цэргүүд Есүсийг инээж нулимж байв. Тэд Есүст хуучин ягаан нөмрөг нөмрүүлээд, хурц өргөстэй титэм хийж Есүсийн толгой дээр тавив. Тэгээд Есүст хүндэтгэл үзүүлэн мөргөсөн.

Цэргүүд

Хаан мандтугай. Иудейн хаан мандтугай, ха ха ха ха

Өгүүлэгч

Цэргүүд Есүсийг загалмайд цовдлохын тулд Түүнд загалмайг үүрүүлэн өндөр толгодыг чиглэн алхуулж байх үед, Есүс загалмайг үүрэхэд хэдийнээ ядарч цөхөрсөн байв. Тиймээс цэргүүд хажууд нь алхаж байсан нэгэн эрэгтэйг олоод түүнд Есүсийн загалмайг үүрэхэд тусал гэж дуудав.

Цэргүүд

Хөөе, чиний нэр хэн бэ?

Симон

Би юу? Аа .. намайг Симон гэдэг.

Цэргүүд

ийшээ ирээд энэ хүний загалмайг үүрэхэд тусал.

Симон

Би ... аа ... ойлголоо ...

Өгүүлэгч

Цэргүүд Есүсийг чирч байх зуур, үй олон хүмүүс болон эмэгтэйчүүд Есүсийг даган явж байсан бөгөөд эмэгтэйчүүд Есүсийг бодон цээжээ дэлсэн цурхиран уйлж байв. Есүс улам доройтож цөхөрсөн байсан ч тэдэнд айлдсан.

Есүс


Иерусалимын охид оо, Миний төлөө уйлахаа боль. Харин өөрсдийнхөө төлөө, хүүхдүүдийнхээ төлөө уйл. Үзэгтүн. “Хүүсэр эмэгтэй болон хэзээ ч хүүхэд тээж байгаагүй хэвлий, мөн хэзээ ч хөхүүлж байгаагүй хөх нь ерөөлтэй еэ!” гэж хэлэгдэх өдрүүд ирж байна. Тэгээд тэд уулсад хандан “Бидэн дээр унаач”, толгодод “Биднийг нөмрөөч” гэх болно. Хэрэв тэд эдгээр ногоон модонд үйлддэг бол хуурай хувхай модонд энэ нь юу болох билээ?


Цэргүүд

Хөөе чи!!! ярихаа болиод хурдан хөдөл!!


Өгүүлэгч

Цэргүүд Есүсийг чирэн Голгот буюу Гавал хэмээх газар аваачив. Тэр үед тэд Симоныг явуулаад Есүст цагаан цуу уулгав. Есүс амтыг нь мэдээд дахиж уух гэсэнгүй.





- Өгүүлэгч** Цэргүүд Есүсийн толгой дээр “Энэ бол Иудейчүүдийн хаан Есүс” гэж бичсэн нүглийн пайз наажээ. Тэгээд загалмайд Есүсийн гар, хөлийг хадаад загалмайг босголоо.
- Есүс** Аав аа, эднийг уучлаач. Тэд өөрсдөө юу хийж байгаагаа ч мэдэхгүй.
- Өгүүлэгч** Тэд Есүсийг загалмайд цовдлох үед цэргүүд шавга хаяцгаан Есүсийн хувцсыг хуваан авчээ.
- Цэргүүд** Энийг хэн авах уу?
- Цэрэг 1** би улаан хувцсыг авъя
- Цэрэг 2** Эхлээд мөнгөө өг
- Өгүүлэгч** Есүс цовдлогдсон газар хоёр гэмт хэрэгтэн байв. Нэг нь Есүсийн баруун талд, нөгөө нь Есүсийн зүүн талд байлаа. Тэдний нэг нь Есүсийг доромжлон хэлэв.
- Гэмт хэрэгтэн 1** Хөөе! чи Христ биш билүү? Өөрийгөө болон биднийг авраач!
- Гэмт хэрэгтэн 2** Чи адилхан ялд унасан атлаа Бурханаас айхгүй байна уу? Бид үйлдсэн хэргийнхээ төлөө зохих хариуг л авсан. Харин энэ хүн ямар ч буруу юм үйлдээгүй шүү. (зөлдөгээр)Есүс ээ, Та Өөрийнхөө хаанчлалд очихдоо намайг санаарай.
- Есүс** Үнэнээр Би чамд хэлье. Өнөөдөр чи Надтай хамт Диваажинд байх болно.
- Цэргүүд, олон түмэн** Хөөе Есүс!! чи Иудейчүүдийн хаан юм бол өөрийгөө авраач!
- Өгүүлэгч** Есүс загалмайд цовдлогдоод маш их зовлон амсав. Цэргүүд Есүсийг шоолон доог тохуу хийсэн боловч Есүст хайртай хүмүүс уйлав. Бүх газар шөнө шиг харанхуйлж эцэст нь Есүс хашгирлаа.
- Есүс** Миний Бурхан, Миний Бурхан, юунд Намайг орхино вэ?
- Олон түмэн** Хараач, Тэр Елиаг дуудаж байна. Хурдан Түүнд уух юм өг. Елиа ирээд Түүнийг буулгахыг харцгаая.
- Өгүүлэгч** Есүс цагаан цуу уугаад дахин айлдав.
- Есүс** Бүгд биелэгдлээ.
- Өгүүлэгч** Есүс энэ үгийг эхлээд чангаар хашгиран амьсгал хураалаа. Тэр үед сүмд өлгөөтэй байсан хөшиг дээрээсээ доош хоёр хэсэг болон хуваагдав.



Өгүүлэгч

Бүх газар тэр чигээрээ хөдөлж чулуунууд хуваагдав. Есүсийг хараад зогсож байсан зуутын дарга Түүнийг амьсгал хураахыг хараад хэлэв.

Зуутын дарга

Энэ хүн үнэхээр Бурханы Хүү байжээ ...

Өгүүлэгч

Есүсийн биеийг загалмайгаас буулгав. Хүмүүсийн дунд Ариматаас ирсэн Иосеф гэгч хүн байв. Тэр баян байсан бөгөөд өөрийнхөө тосгонд хүндэтгэл хүлээсэн зөвлөлийн гишүүн байсан юм. Тэр Пилат дээр очоод Есүсийн цогцсыг өгөөч гэв. Иосеф маалинган даавуу авчирч Есүсийн цогцсыг буулгаж ороон чулуу зүсэж хийсэн булшинд оруулж тавиад үүдийг нь чулуу өнхөрүүлэн хааж орхив. Есүсийн эх Мариа болон Магдалын Мариа, Иосефын эх Мариа нар Есүсийн цогцсыг хаана тавьж байгааг харж байлаа.

